



МОНГОЛ УЛС  
ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2014 оны 04 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай


Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 44 дүгээр тушаалаар баталсан "Хэмжил зүйн зөвлөлийн дүрэм"-ийн 1.4 дэх хэсгийг "Зөвлөлийн шийдвэр нь хуралдаанаас гарах зөвлөмж байх бөгөөд хуралдааны үед тэмдэглэл хөтөлнө" гэж, 6.2 дахь хэсгийг "Зөвлөлийн дарга нь хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулж, түүнээс гарах зөвлөмжийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын дарга тушаал гаргана" гэж тус тус шинэчлэн найруулж нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх нэмэлт өөрчлөлтийг баталсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга бөгөөд Хэмжил зүйн зөвлөлийн дарга /Г.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар сайд

Д.ТЭРБИШДАГВА





МОНГОЛ УЛС  
ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2012 оны 11 дугаар  
сарын 27 -ны өдөр


Дугаар 44

Улаанбаатар,  
хот

Зөвлөлийн дүрэм батлах тухай

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсэг, Стандартчилал, хэмжил зүйн газрын саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хэмжил зүйн зөвлөлийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Шинээр батлагдсан дүрмийг 2012 оны 12 дугаар сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Хэмжил зүйн зөвлөлийн дарга (Г.Энхтайван)-д үүрэг болгосугай.



Монгол Улсын Шадар сайд

Д.ТЭРБИШДАГВА

## ХЭМЖИЛ ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Энэхүү дүрэм нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангахын тулд хэмжил зүйн асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах зорилго бүхий Хэмжил зүйн зөвлөл /цаашид: "Зөвлөл" гэх/-ийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах зарчим, эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тогтооно.

### I. Ерөнхий зүйл

1.1 Хэмжил зүйн төв байгууллагын Хэмжил зүйн зөвлөл нь мэргэжлийн байгууллагаас боловсруулсан хэмжил зүйн асуудлыг шийдвэрлэх талаар хамтран хуралдаж, зөвлөлдөх байнгын ажиллагаатай, орон тооны бус байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, бусад хуулийн шаардлагад нийцүүлэн явуулна.

1.2 Зөвлөлийн бүрэлдэхүүнд хэмжил зүйн салбарт мэргэшсэн, нэр хүнд бүхий мэргэжилтнүүд, тухайн салбарын мэргэжлийн хяналт шалгалт, үнэлгээний албаны дарга нар, шинжлэх-ухааны байгууллагын эрдэмтэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл орно.

1.3 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

1.4 Зөвлөлийн шийдвэр нь хуралдааны тэмдэглэл, түүнийг үндэслэн гаргах Хэмжил зүйн зөвлөлийн тогтоол байна.

### II. Зөвлөлийн зорилго ба зорилт

2.1 Зөвлөлийн зорилго нь Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлага, дэлхийн улс орны жишигт нийцүүлэн Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах шинжлэх ухааны, техникийн, зохион байгуулалтын болон эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хэмжил зүйн талаар төрөөс дэвшүүлсэн бодлого, чиглэлийн хэрэгжилтийг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хангах асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргахад оршино.

2.2 Зөвлөлийн зорилт нь Монгол Улсад хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулахад чиглэх бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлбол:

- хэмжил зүй, хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах салбарт төрөөс баримтлах нэгдсэн техникийн бодлого боловсруулах ба хэрэгжүүлэхэд эдийн засаг, нийгмийн зонхилох салбарын яам, агентлаг, шинжлэх ухааны байгууллага, аж ахуйн нэгжийг өргөнөөр татан оролцуулах;
- хэмжлийн нэгжийн олон улсын систем (SI)-ийг Монгол Улсад бүрэн нэвтрүүлэх;
- хэмжлийн нэгжийн үндэсний эталоны нарийвчлалыг олон улсын гүтэшинд ойртуулах;



- эталоны баазыг бэхжүүлэх, нэгж дамжуулалтын тогтолцоог бүрдүүлэх;
- хэмжих хэрэгслийн загварын туршилт, баталгаажуулалт, тусгай зөвшөөрлийн түвшин, цар хүрээг нэмэгдүүлэх;
- хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах талаар нийгэм, олон түмний ухамсрыг бүрэлдэн тогтоход дэмжлэг үзүүлэх;
- хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах салбарт Хэмжил зүйн төв байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааны үндсэн чиглэлээр нийгэм, хэрэглэгчдийн мэдээллээр хангагдах боломжийг дээшлүүлэх;
- Хэмжил зүйн төв байгууллагаас яам, тусгай газар, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах үйл ажиллагааг боловсронгуй болгоход оршино.

### III. Зөвлөлийн зохион байгуулалт, бүтэц, ажиллах зарчим

3.1 Засгийн газар Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилохдоо хэмжил зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, тухайн салбарын сайд, агентлагийн дарга, Хэмжил зүйн төв байгууллагын даргын саналыг үндэслэнэ.

3.2 Зөвлөлийг Хэмжил зүйн төв байгууллагын дарга тэргүүлнэ.

3.3 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн хуралдааны зохион байгуулалтын ажлыг хариуцаж, баталсан дэгийн дагуу Хэмжил зүйн зөвлөлийн худалдааны бэлтгэлийг хангах, үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийг баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.

3.4 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, ил тод нээлттэй, аль нэг байгууллага, иргэний явцуу эрх ашгийг хамгаалахгүй, ашиг сонирхлын зөрчилгүй байх, хамтын удирдлагын зарчмыг баримтлан аливаа асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.5 Зөвлөл нь үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болон түүний бүрэн эрхэд хамаарах бусад асуудлаар санал боловсруулж, Хэмжил зүйн төв байгууллагын удирдлагад танилцуулна.

3.6 Зөвлөл нь жил жилийн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу ээлжит хуралдааныг сард нэгээс доошгүй удаа хийнэ.

3.7 Зөвлөл нь ээлжит бус хуралдааныг хийж болно.

3.8 Зөвлөлийн гишүүдийн нэрсийн жагсаалтын 50-иас доошгүй хувийн ирц бүрдсэн тохиолдолд хуралдаан хүчин төгөлдөр болно.

3.9 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь даргатай тохиролцсоны дагуу Зөвлөлийн ээлжит хуралдааны хөтөлбөрийг хуралдаан болохоос ажлын 5 хоногийн өмнө, хуралдааны тэмдэглэлийн төслийг хуралдаан болсны дараа ажлын 7 хоногт багтаан боловсруулж, батлуулсан байна.

3.10 Зөвлөлийн гишүүдэд ээлжит хуралдааны хугацаа, хөтөлбөр, ажлын материалууд ба шийдвэрийн төслийг уг хуралдаан болохоос 3 хоногийн өмнө цаасан хэлбэрээр хэлбэрээр буюу эсвэл цахим шуудангаар хүргүүлсэн байна.

3.11 Зөвлөлийн гишүүд нь ээлжит хуралдааны хөтөлбөрт туссан асуудал ба гарах шийдвэрийн төсөлд өөрсдийн саналаа урьдчилан бичгээр буюу электрон хэлбэрээр ирүүлэх буюу хуралдаан болох тэр өдөр нь өгөх эрхтэй.

3.12 Зөвлөлийн гишүүдээс хэлэлцүүлэхээр нэмж оруулж байгаа асуудлыг Зөвлөлийн шийдвэрээр тухайн өдрийн буюу эсвэл дараагийн хуралдааны хэлэлцэх асуудлын хөтөлбөрт оруулна.

3.13 Хуралдааны тэмдэглэлд Зөвлөлийн дарга, хэмжил зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

3.14 Зөвлөл нь албан хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэнэ.

3.15 Зөвлөлийн үйл ажиллагаа, шаардлагатай материалыг Хэмжил зүйн төв байгууллагын вэб хуудас, сэтгүүл, интернет болон төвийн мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

3.16 Зөвлөлийн үйл ажиллагааны зардал, техник хангамж, хөрөнгө, санхүүгийн асуудлыг Хэмжил зүйн төв байгууллага хариуцаж, жил жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

#### **IV. Зөвлөлийн эрх**

4.1 Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлого, хэтийн чиглэлийн төслийг хэлэлцэж, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх;

4.2 Хэмжлийн нэгж, нэгжийн улсын болон анхдагч эталоныг бий болгох техникийн даалгавар, тэдгээрийн олон улсын болон гадаад улс орны хэмжил зүйн байгууллагад харьцуулан дүйлгэж, шалгалт тохируулгад хамруулсан үр дүнг хэлэлцэх, батлах;

4.3 Хэмжил зүйн төрийн хяналт шалгалтад хамруулах хэмжих хэрэгслийн жагсаалт болон хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт, шалгалт тохируулга, загварын туршилт хийх ажлын зохион байгуулалт мөн хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хэмжил зүйн төрийн хяналт шалгалтын асуудлыг зохицуулсан дүрэм, журмын төсөл, ажлын үр дүнгүүдийг хэлэлцэх, батлах;

4.4 Бодис, материалын бүтэц, шинж чанарын стандартчилсан загварын хэмжил зүйн аттестатчилал, баталгаажуулалтын дүнг хэлэлцэх, батлах;

4.5 Олон улсын хэмжил зүйн байгууллагад гишүүнээр элсэх асуудлыг хэлэлцэх, холбогдох дээд байгууллагад уламжлах, олон улсын болон бүс нутаг, гадаад орны хэмжил зүйн байгууллагаас зохиогдох арга хэмжээнд эрхэлсэн асуудлынхаа хүрээнд оролцох;

4.6 Хэмжил зүйн төв байгууллага болон итгэмжлэгдсэн хэмжил зүйн алба, лабораториуд, тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаас шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангагдах;



4.7 Хэмжил зүйн холбогдолтой улсын стандартуудын мөрделт, хэрэгжилтийг хэлэлцэж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

## **V. Зөвлөлийн үүрэг**

5.1 Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн Хууль, бусад хууль, дүрэм, журам, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах суурь стандартууд, Хэмжил зүйн төв байгууллагын үйл ажиллагааны стратеги болон энэхүү дүрмийг удирдлага болгон мөрдөнө.

5.2 Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, шинэчлэх, өөрчлөлт оруулах тухай санал гаргах;

5.3 Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хэтийн чиглэл, хөтөлбөр, төсөл, улсын стандарт, дүрэм, журам боловсруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, төлөөлсөн салбарын бодлогыг тусгах, зохицуулах;

5.4 Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль, эрх зүйн орчин, шинжлэх ухааны үндэс, техникийн болон зохион байгуулалтын үндсийг олон улсын жишиг, улс орны нийгэм, эдийн засгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох талаар мэргэжлийн байгууллагаас боловсруулсан аливаа асуудлыг сайтар хэлэлцэж, холбогдох хуульд нийцсэн хуралдааны тэмдэглэл гаргах;

5.5 Гишүүд нь төлөөлсөн салбарынхаа хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах бодлого, чиглэлийн төслийг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, Монгол Улсын Хэмжлийн тогтолцооны хөгжлийн хэтийн чиглэлтэй уялдуулсан байх;

5.6 Хэмжил зүйн төрийн хяналт шалгалтын мэдээ, тайлантай танилцах, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагуудаас судалгаа гаргуулан, дүгнэлт гаргах, мэргэжил, арга зүйн чиглэл өгөх;

5.7 Хариуцсан салбартаа хэмжил зүйн чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

## **VI. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын үйл ажиллагааны чиглэл**

6.1 Зөвлөлийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлыг баталж, хурлын дэгийг баримтлан хурлыг удирдан явуулна.

6.2 Зөвлөлийн дарга нь хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулж, түүний хэрэгжилтийг хангуулах Хэмжил зүйн зөвлөлийн тогтоол гаргана.

6.3 Зөвлөлийн даргаас гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж, гишүүдийн ажлын оролцоог үнэлж дүгнэн, урамшуулал олгоно.

6.4 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.

6.5 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын бэлтгэлийг ханган, хурлын тэмдэглэл хөтөлж, гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

6.6 Хэмжил зүйн зөвлөлийн хэлэлцсэн асуудлаар мэдээллийн санг бүрдүүлж, гишүүдийг мэдээллээр хангах;

6.7 Зөвлөлийн архив, бичиг хэргийг хөтлөн явуулна.

Төгсөв